

ГЛОБАЛ САНХҮҮГИЙН ХЯМРАЛ: СУРГАМЖ, СОРИЛТ*Ц.Баатар**

2008 оны голбал санхүүгийн хямрал, түүний учир шалтгааныг шинжээчид өнөө өөр өөр өнцгөөс харж янз бүрээр үнэлж дүгнэж байна.

Америкийн Холбооны нөөцийн систем цаг тухайд нь арга хэмжээ авч “Lehman Brothers” банкыг дампууруулаагүй бол ийм байдалд орохгүй байсан. Энэ банкыг дампууруулснаар дэлхийн хөрөнгийн зах зээлийг унагаж ийм уршигт үр дагаварт хүргэсэн болохыг 2008 оны Нобелийн шагналт Америкийн нэрт эдийн засагч Paul Ktugman саяхан бичсэн “The Return of Depression Economics and the Crisis of 2008” хэмээх бүтээлдээ тал бүрээс нь шинжилж үнэлэлт дүгнэлт өгсөн байна. (December, 2008) Энэхүү бэсрэг өгүүлэлд глобал санхүүгийн хямрал, түүний олгож буй сургамж, сорилтын талаар тоймлон цухас өгүүлэх оролдлого хийлээ.

1997 оны Зүүн Азийн санхүүгийн хямрал хөрөнгийн урсгалыг нээлтэй болгох нь ямар аюул дагуулдгийг харуулсан бөгөөд түүнээс хойш нээлтэй болгох асуудалд итгэх итгэл хөсөр унасан гэж хэлж юм. Үүний улмаас шийдэж болох асуудал хэмээн үзэж байсан өдий төдий зүйл дахиад л эдийн засгийн маргаан мэтгэлцээний талбарт гарч ирсэн билээ.

Тэр ч бүү хэл, санхүүгийн глобалчлал, чөлөөт зах зээл бүхнийг зохицуулдаг гэсэн үзэл баримтлал тэр бүр хүсэн хүлээсэн үр дүнг улс орнуудад өгөөд байдаггүй болохыг бодит амьдрал нотлон харууллаа. Нэгд, хөрөнгө заавал баян чинээлэг орноос ядуу буурай улсуудад урсан орж ирдэггүй гэдэг нь тодорхой болов. Нобелийн шагналт Ж.Стиглиц бүр 2003 онд “Дэлхийн санхүүгийн системд ямар нэгэн гажуудал байна. Уг системд эрсдэл нь ядуу орноос түүний аяыг даах баян улс орнуудад экспортлогдох бөгөөд мөнгө хөрөнгө ихтэй баян чинээлэг орнуудаас хөрөнгө хомсхон ядуу буурай улсууд итмпортлон авдаг хэмээн зарим хүн боддог... Өнөөгийн дэлхий дахины санхүүгийн системд эдгээр зүйлийн аль аль нь алга” (2003) гэснийг өнөөгийн үйл явцын өрнөлт батлан харуулж байна.

Энэ сэдвээр эрдэмтэдийн хийсэн олон судалгаанаас үзэхэд, хамгийн их анхаарал татаж буй асуудал бол санхүүгийн интеграцчлалын хэр хэмжээ болон өсөлтийн үр дүнгийн үзүүлэлт хоёрын хоорондох тохиолдлын тодорхой харьцааг тогтооход бэрхтэй байдаг аж. Санхүүгийн глобалчлалд илүү идэвхтэй оролцож буй хөгжиж буй орнууд дахь өсөлтийн үр дүнг дунджаар аваад үзвэл глобалчлалд оролцоогүй орнуудынхаас илүү тодорхой бөгөөд

*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

нааштай харьцаа байна гэх үнэмшилтэй нотолгоо даанч алга. Бүхэлдээ санхүүгийн глобалчлал ашиг тустай гэх өөдрөг хүлээлт биелэлээ олохгүй байна. Нилээд улс орон санхүүгийн глобалчлалд нэгдэн, хөрөнгийн хөдөлгөөнөө чөлөөтэй болгосон хэдий ч байдал нь ихэд тогтворгүй болж, өсөлтийн үзүүлэлтүүд нь ихээхэн саарчээ.

Дээр өгүүлсний нэгэн адил худалдааны системийн нөөц боломжийн талаархи сэтгэгдэл анхандаа оргилуун байсан боловч бодит үр дүн хүсэн хүлээснээс тааруу байгаа нь тодорхой болж ирмэгц эрүүл саруул үнэлэлт дүгнэлт улам бүр ихсэж байна. Уругвайн цуврал хэлэлцээний хэрэгжилт хөгжиж буй орнуудад гол төлөв ихээхэн зардал төвөг учруулдаг, амлаж байсан өдий төдий ашиг тус хоосон зүйл болж, зарим нь удтал үргэлжилсэн шилжилтийн үеүдийн дараа л сая биелэлээ олох нь бас тодорхой боллоо.

Дэлхий дахин бүхэлдээ глобалчлалын ач тусыг хүртэж байвч түүнд базаахгүй бөгөөд тус нэмэр багатай талууд ч байгааг үгүйсгэх аргагүй. Глобалчлалын эхний базаахгүй тал гэвэл, түүний ашиг тус улс орнуудын хооронд болон дунд жигд хүртээмжтэй байдаггүй явдал юм (хөгжиж буй орнуудын тухайд бол тэрхүү ашиг тусыг хүртэнэ гэдэг илүү бэрхшээл түвэгтэй. Энэ нь тухайн улс орны засаглалын чадавхитай нягт уялдаа холбоотой-Ц.Б).

Түүгээр ч зогсохгүй өнгөцхөн харахад нэг хэсэг улс орны хувьд энэ бодлого ашиг тустай мэт боловч нөгөө зарим нь тийм ч нааштай үр дүнд хүрч чадахгүй байгаа болохоор худалдааг чөлөөтэй болгоно гэдэг нь өсөлт хөгжилд зайлшгүй чухал үр нөлөөтэй гэдэг үзэл баримтлал өргөн олны дэмжлэг төдий л авч чадахгүй байна. Нөгөө талаар амжилт олсон, тухайлбал Зүүн Азийн улс орнуудыг худалдааг чөлөөтэй болгохын үлгэр дууриал болсон гэж судлаачид үздэггүй. Худалдааг нээлттэй болгох нь өсөлтийг хурдасгахын баталгаа биш гэдгийг Берг, Крюгер нар түүвэр судлагааныхаа үндсэн дээр “шинэчлэлийн үйл явцын нэг хэсэг болгож тодорхой хэмжээний нээлттэй бодлого явуулснаар саяхнаас хүчээ авсан улс орнуудын жишээ байхгүй байна гэсэн ганц айхтар дүгнэлт сүүлийн 20 жилийн туршлагаас үүдэн гарч байна” (2003) гэжээ. Түүнчлэн Луцийн цохон тэмдэглэсэнчлэн, худалдаанд хязгаарлалт тогтоох нь хөгжиж буй орнуудын өсөлтөд ашиг тустай хэмээсэн нотолгоо ерөөс байхгүй. Өөрөөр хэлбэл, худалдааг нээлттэй болгох нь шаардлагатай зүйл мэт боловч өсөлтөд нөлөөлөх хангалттай хүчин зүйл, бодит нөхцөл биш аж. Энэ нь бодлогын нөлөөллийн хувьд мэдээж чухал зүйл. Түрүүчийн хэсэгт нэгэнт санал болгосончлон худалдааны либералчлал нь дангаараа бүх асуудлыг шийдвэрлэж чадахгүй бөгөөд үр дүнг нь хэт дөвийлгөж болохгүй гэдгийг эрдэмтэдийн судалгаа нотлон харууллаа.

Тийнхүү дан ганц эдийн засгийн интеграцлал өсөн нэмэгдсэнээр өсөлт хөгжлийн асуудал шийдэгдэхгүй гэдгийг олон нийт улам бүр хүлээн зөвшөөрч байна. Худалдаа ихээхэн либералчлагдаж байгаа боловч буурай хөгжилтэй олон улс орон ядуурлыг үлэмж хэмжээгээр тэр бүр бууруулж чадсангүй, заримых нь өсөлт хөгжил тааруухан байгааг бид мэдэх билээ. Ядуурал, байгаль орчны сүйрлийн дүнд л глобалчлалын ашиг тус гарах байх хэмээн хааяагүй болгоомжилж, тэр нь ажилчдын эрхийн төлөө тэмцэл иргэний нийгмийн эсэргүүцлийн өргөн хүрээтэй хөдөлгөөнөөр илэрч байна. Эсэргүүцэл нь үндсэрхэх үзэл болон ивээн тэтгэгчдийн турхилтаар ихэсэх хандлагатай байна. (2004) Хэрэв нягт харилцан хамаарал бүхий интеграцид орохыг хүсвэл бүх юм нэгдмэл байх ёстой гэсэн үзэл баримтлалд өөрчлөлт гарч буйг ЕХ-ны баримталж буй бодлого үйл ажиллагаанаас харагдаж байна. Тухайлбал, Европын Холбоо цаашид либералчлах явдлыг хөгжиж буй орнуудад тохирох цорын ганц стратеги хэмээн үзэж, түүнээ учир зүтгүй хамгаалан энэ үзэл баримтлалаа тэдэнд тулган хүлээлгэж байсан чиг хандлагаа өнөө нэгэнт орхисон зэргээс харагдана.

1990-ээд оны Зүүн Азийн санхүүгийн хямралын нэгэн томоохон сургамж гэвэл худалдаа болон санхүүгийн нээлттэй байдлын ашиг тус аяндаа бий болдоггүй, харин үүний тулд нэмэлт олон арга хэмжээ авах шаардлагатай гэдгийг харуулсан явдал юм.

Худалдааны тухайд бол худалдааны шинэ хэв маяг өсөлт хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг сүүлийн үеийн зарим судлагаа харуулж байна. Экспортыг дагнах асуудлын эерэг сөрөг талыг Плумпер, Графф нарын судлагаа тодорхой харуулсан байдаг. (2001) Тухайлбал, тэд өндөр технологийн бараа таваарын өрсөлдөхүйц давуу талтай худалдаа нь эдийн засгийн үзүүлэлтэд илүү их таатай үр нөлөө үзүүлж байхад ердийн бараа таваар эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нь тун тааруухан нөлөө үзүүлдэг болохыг олж тогтоожээ. Тэдний судлагааны үр дүн Сачс, Уорнер нарынхтай таарч байна. (1999) Ийнхүү эрдэмтэдийн хийсэн олон судалгаанаас үзэхэд түүхий эдийн харьцангуй давуу тал өсөлт хөгжилд тун шалихгүй нөлөө үзүүлдэг болохыг тал бүрээс нь нэгэнт нотлон харуулсан билээ. Тухайлбал, олон улсын хэмжээнд ихээхэн эрэлттэй байгаа бүтээгдэхүүнийг дагнах нь үр ашгийг сайжруулахад түлхэц болдог учир өсөлтөд сайнаар нөлөөлдгийг харуулсан билээ. Эдгээр судалгааны гол үр дүн, чухал ач холбогдол гэвэл, хөгжиж буй орнуудад аж үйлдвэрийн бодлогын зарим тодорхой хэлбэр зайлшгүй шаардлагатай болохыг нотлон харуулсан явдал юм.

Сүүлийн үеийн судалгааны бүтээлд олонтаа тэмдэглэж буй бас нэг чухал сургамж нь нэмэлт арга хэмжээ чухал болохоос гадна, тухайн улс орны засаглалын чадавхи чухал үүрэгтэй болохыг олонтаа

анхааруулж буй нь анхаарал татаж байна. Түүнчлэн эрдэмтэдийн онцлон тэмдэглэснээр бол боловсролын чанар, засаглалын чадавхи хийгээд төрийн бус байгууллагууд нь олон улсын жишигт хүрсэн байх явдал аж. Эдгээрийн аль нэг нь байхгүй бол өсөлт хөгжлийн тухай ярих нь утга учиргүй байдаг гэнэ. Дээрхи асуудал өсөлт хөгжилд хичнээн чухал болохыг Родрикийн судалгаа ч давхар нотлон харуулж байна. (2007) Ийнхүү хэд хэдэн судлагаанаас нэгэн адил дүгнэлт гарч, өсөлт хөгжилд нөлөө үзүүлэхийн тулд нээлттэй байдлыг бусад уян хатан бодлоготой нягт уялдуулан хослуулах нь чухал ач холбогдолтой болохыг цохон заажээ.

Дэлхийг хамарсан санхүүгийн өнөөгийн хямралын тухайд бол урьд өмнө гарч байсан урам хугалсан үр дүнг санхүүгийн глобалчлалтай холбон тэр нь заавал нэг хор хохирол учруулж байдгийн нотолгоо мэтээр тайлбарлах нь утга учиргүй, харин санхүүгийн глобалчлалын ашиг тус аяндаа гардаггүйн илрэл хэмээн энгийн ойлгож болно. Козегийн тайлбарлаж байгаагаар бол санхүүгийн глобалчлал нь маш өвөрмөц байдалд, тухайлбал зарим нөхцөл боломж бүрдэж, тодорхой босгонд хүрсэн үед л нааштай үр дүнгээ өгдөг. Боломж бүрдүүлсэн эдгээр нөхцөл нь тухайлбал санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин, байгууллын чанар, макро эдийн засгийн бодлого юмуу худалдааны интеграчлалын хэр хэмжээтэй холбоотой байдаг аж. (2007)

Тодорхой жишээгээр харуулахад адил тэгш бус хяналттай санхүүгийн систем болон банкны сул дорой байгууллагуудаар зуучлуулах үед богино хугацааны капитал их хэмжээгээр урсан орж ирэх, гэнэт гарах нь хөрөнгийн урсгал, тухайлбал өмчийн зээлийн бужигнасан орчлын улмаас томоохон саад бэрхшээл үүсгэж болох магадлал өндөр байдаг аж. Ийм тохиолдлуудад мөн чанартаа санхүүгийн глобалчлалд учир начир нь байгаа юм биш үнэн хэрэгтээ дотоодын санхүүгийн системийн сул дорой байдал (хяналт шалгалт хангалттай бус байх, банкууд эрсдлийн үнэлгээг зохих ёсоор хийхгүй байх гэх мэт) хямралын уг үндэс болдог гэдгийг энэ үе шатанд дурдах нь зүйтэй. Үүнийг өнөөгийн Америкийн санхүүгийн хямралын жишээ харуулж байна. Америкийн банкууд ямарч хяналтгүйгээр орон сууцны зээлийг асар их хэмжээгээр олгосон. Уг зээл үнэт цаасны зах зээлээр дамжин үнэ нь хэд нугарч олон эзэмшигчтэй болж яваандаа тэр нь хяналтаас гарснаар үнэт цаасны зах зээлийн хямрал даамжирч, улмаар орон сууцны моргейжийн зээл их хэмжээгээр олгосон “Lehman Brothers” зэрэг банкууд дамуурсан. Цаашлаад түүний хор уршиг өвсөнд ассан түймэр шиг бараг дэлхийг хөлдөө чирээд байна. Америкийн эдийн засаг бүхэлдээ үнэт цаас, хувьцаан дээр тогтож, томоохон хөрөнгийн биржийн индекс түүний хувь заяг тодорхойлж байлаа. Америкийн орон сууцанд зориулж

олгосон нийт зээлийн хэмжээ 11 триллион ам.доллар болж, эдийн засгийнхаа 80 хувьд хүргэж зээл олгосон гэсэн үг юм. (December, 2008) Олон улсын валютын сангийн таамаглалаар бол АНУ-ын ипотекийн зах зээлийн хямрал 2009 онд төгсгөлийн шатандаа орж, үүнээс улбаалан дэлхийн хамгийн томд тооцогдох АНУ-ын эдийн засгийн өсөлтийг сааруулж байсан сөрөг нөлөөлөл буурч, аажмаар өсч эхлэх аж. (October, 2008) Бодит байдал дээр ч нааштай хандлагууд ажиглагдаж эхэллээ. Тухайлбал, томоохон биржүүдийн хувьцааны үнэ тогтворжсоноор барахгүй өсч байна. Дэлхий даяар, улс орон, бүс нутаг бүхэн энэ тал дээр санаа зовинож авралын нүсэр төлөвлөгөөнүүдийг хамтран хэрэгжүүлж эхэллээ. Дэлхийн тэргүүлэх эдийн засагтай гүрний хувьд АНУ санхүүгийн системээ эрүүлжүүлэхийн тулд бүхнийг хийж байна. Энэ бүхнээс үзэхэд Америкийн санхүүгийн хямралын хүнд өвчин удахгүй илаарших нь нэгэнт тодорхой болж хямралын сорилтыг амжилттай даван туулж байна.

Хөгжиж байгаа орнуудын хувьд дэлхийн санхүүгийн хямралд харьцангуй бага өртсөн бөгөөд тэдний үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдал нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байна гэж Олон улсын валютын сангийн тайланд тэмдэглэсэн байна.

Олон улсын санхүүгийн орчин нөхцөл нь тухайн орны засаглалын тогтолцоо, түүний технологийн чанар чансаатай уялдаагүй байх аваас тэр нь аливаа саад бэрхшээлийн томоохон эх үүсвэр болдог гэдгийг Америкийн жишээ харуулж байна.

Санхүүгийн глобалчлалын тухайд бол, бусад зүйлсийн зэрэгцээ шинэ тутам гарч ирж буй нэгдмэл үзэл баримтлал нь эдийн засгийн өвөрмөц нөхцөл байдлын шаардлагаар капиталд хяналт тавьж болохыг харуулж байна. Бүс нутгийн хэмжээний бас нэг чухал сургамж байгаа бөгөөд тэр нь тухайлбал өөртөө туслах хамтын механизмаар дамжин санхүүгийн глобалчлалтай холбогдсон эрсдлүүдийг зөөлрүүлэхэд туслаж чадна. 1997-98 оны санхүүгийн хямралын дараагаар АСЕАН+3 бүлгийн орнууд Чиаан Майгийн Санаачилга гэгчийг хэрэгжүүлж байсан нь бүс нутгийн ийм системийн нэг жишээ юм.

Бодлогын нөлөөллийн хувьд “глобалчлалын менежментийн” зарим нэг хэлбэрийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Хөгжиж буй орнуудын тухайд бол эдийн засгийн даяаршлын далд ашиг тусыг ухаалгаар үнэлэн дүгнэх аваас глобалчлалын тэрхүү ач тусыг бүрэн дүүрэн нээн харуулах бололцоо олгохуйц зүй зохистой нөхцөл бүрдүүлэх нь хамгийн чухал. Үүний тулд юуны өмнө засаглалын тогтолцоо эрүүл саруул байх явдал юм. Тогтолцооны гажиг архаг хууч өвчнөөс салж эрүүл саруул болмогц глобал гадаад орчны хөгжлийн

асар хурдтай хувьсал өөрчлөлтөнд богино хугацаанд дасан зохицохын тулд “шинэ үйлдвэржилтийн бодлого”-ыг гаргаж тавих ёстой.

Санхүүгийн глобалчлалын төлөв байдлыг сайтар ажиглан харвал түүнд байгаа зохисгүй бүхий л үр дагавар нь үндэсний юм уу дэлхий дахины хэмжээнд, эс бөгөөс аль аль түвшинд засаглал бүтэлгүй байгаагаас болж байна. Засаглал гэдэг бол төрийн үйлчилгээний нэртэй байгууллагууд олноор бий болж, тэд оршин тогтнохын тулд элдэв янзын дүрэм журам их хэмжээгээр үйлдвэрлэж, аливаа үйл ажиллагаанд хэмжээ хязгаар тогтоон, хувь хүмүүс, байгууллага, пүүс компаниудын өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байдаг нэгэнт тогтсон зүй бус үйл ажиллагааны нэгдэл гэж хэлж болох юм. Чухам тийм учраас хөгжиж буй орнууд глобалчлалыг урагшлуулахын тулд дотоодлоо засаглалын тогтолцоогоо эрүүлжүүлж, үндэсний болон олон тал (эсвэл бүс нутгийн)-ын хүч чармайлтаа хослуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Найярын нотлож байгаагаар, “Либералчлал, глобалчлалын ертөнцөд хөгжлийн аливаа ухаалаг стратегийн зорилго нь үндэсний эрх ашиг, хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх эдийн засгийн орон зайг бүрдүүлэх явдал байдаг аж (1997). Үүний тулд дотоодлоо эдийн засгийн бодлогын хүрээнд төдийгүй гадаад ертөнцтэй эдийн засаг, улс төрийн салбарт нягт хамтран ажиллахад л төрийн стратегийн бодлого, үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх учиртай. Үндэсний хэмжээнд төр нь хөгжил дэвшилд илүү тааламжтай угтвар нөхцөл бүрдүүлж, хил дамжсан эдийн засгийн үйл ажиллагаанаас олсон ашгийн хуваарилалтыг сайжруулах үүднээс олон улсын капиталаар арилжаа хийх, эмзэг байдлыг багасгахын тулд эдийн засгийн макро түвшний удирдлагад ухаалгаар хандах, бас глобалчлалтай холбогдсон нийгмийн зардлыг бууруулах үүднээс хөндлөнгөөс оролдох хүсэл эрмэлзэлтэй байх ёстой. Олон улсын хэмжээнд төр нь тоглолтын дүрэм журмын тэгш хэмгүй, адил тэгш бус байдлыг багасгах, энэ зорилгын үүднээс хөгжиж буй орнуудын дунд стратегийн түншлэл бий болгохын тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж, эрчимтэй, шуурхай ажиллах явдал чухал юм.

Өнөөгийн санхүүгийн хямрал нэг үгээр хэлбэл улс орнуудын засаглалын тогтолцоо, түүний технологийн чанар чансаа, хариуцлага, хяналт, эдийн засгийн чадавхийг нээн харуулж өглөө. Барууны ертөнц тэр аяараа шахуу санхүүгийн хямралд өртөөд байхад Америкийн хаяанд оршдог Канадад бараг юу ч болоогүй юм шиг тайван өнгөөрөх хандлагатай байна. Канадын нэг ч банк, хөрөнгийн бирж хямралд өртсөнгүй. Нэг үгээр хэлбэл Канад Америкийн санхүүгийн хямралаас улс орноо бүрэн бүтнээр нь авч үлдэж чадлаа. Канад Америкаас асар их харилцан хамааралтай хэдий ч хөгжлийн үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлдэг өөрийн гэсэн өвөрмөц засаглалын технологийн шилдэг

загвартай, бүх салбарт хариуцлага, сахилга хяналт сонгодог утгаараа хэрэгждэг орон гэдгээ харуулж Америкийн санхүүгийн хямралд тэгтлээ их хөл алдсангүй. Мэдээж хэрэг Америк гадаад худалдааных нь асар том, итгэлтэй түнш нь болдгийн хувьд Америктай хийж буй худалдааны эргэлт багасах, агаарын тээврийн болон автомашин үйлдвэрлэлийн томоохон компаниудын байдалд ихээхэн хүндрэл бэршээл учирч ажлын байр хумигдаж байгаа хэдий ч урд хөрш Америктай харьцуулшгүй давуу байдалд байна. Энэ бүхэн нь дээр өгүүлсэн Канадын хөгжлийн үзэл баримтлал, бодлого үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

Азийн орнуудаас дэлхийн санхүүгийн өнөөгийн хямралаас хамгийн их ашиг хүртэж буй орны нэгэнд Япон улс зүй ёсоор орно. Санхүүгийн энэ асар их хямралын үед хямралыг боломж хэмээн үзсэн улс бол Япон гэж хэлэх бүрэн үндэстэй. Хэдийгээр Японы эдийн засгийн өсөлт хөгжил зогсонги байдалтай байгаа хэдий ч АНУ, Европыг доргиосон санхүүгийн сүйрлийг Япон улс ажралгүй тойрон өнгөрөөж чадлаа. Түүгээр ч зогсохгүй Япон улсын санхүүгийн байгууллага, аж үйлдвэрийн корпорацитууд хамтран санхүүгийн менежмент маш сайн хийж энэхүү хямралын үед дэлхийд өөрийн нэр хүнд, гадаад зах зээлийн цар хүрээгээ улам бүр өргөжүүлж чадлаа. Энэхүү хямралын үеэр Японы хамгийн том үнэт цаасны компани Mitsubishi UFJ Financial and Mizuho нь Morgan Staley болон Merrill Lynch-ийн гол хувьцаануудыг худалдаж авсан юм.

2008 оны хувьд Японы урсгал тэнцэл 200 тэрбум ам.долларын ашигтай гарсан явдал барууны орнуудыг хамгийн гайхшруулсан зүйл боллоо. 1989 онд Японы урсгал тэнцэл 57 тэрбум ам.долларын ашигтай гарч байсан тэр үеэс гурав дахин их байгаа нь Япон менежмент барууныхнаас ч илүү хүчирхэг болохыг нотолж буй хэрэг.

Өнгөрөн одож буй 2008 онд Америкийн санхүүгийн алдагдал 700 тэрбум долларт хүрч АНУ-ын эдийн засаг маш эгзэгтэй хүнд байдалд байхад Японы урсгал тэнцэл тийм ашигтай гарч байдаг. Японы нууц юунд байна вэ. Үүнд хамгийн их нөлөө үзүүлсэн суурь хүчин зүйл гэвэл Япон өндөр хөгжилтэй үйлдвэрлэлийн байр сууриа хадгалан үлдэж байгаадаа биш харин үнэн хэрэгтээ үүнийг цаашид улам өргөжүүлж чадсанд гол нууц нь оршино. Үүний үр дүнд дэлхийн өнцөг булан бүрт тархан байрласан Америкийн корпорацуудын тэргүүлж байсан аж үйлдвэрийн салбаруудад Япончууд ноёрхлоо тогтоож, байр сууриа баттай эзэлж чадсан явдал юм. Америкчуудын хувьд санхүүгийн хямралд гол анхаарлаа хандуулаад дэлхийн худалдааны гол суурь өөрчлөлтүүдэд хайнга хандсанаас зах зээлд эзлэх байр сууриа ийнхүү Японд алдлаа. Япончууд бараагаа АНУ руу “Японд үйлдвэрлэв” худалдааны тэмдэгтэйгээр экспортлож байсан

бөгөөд энэхүү экспорт нь Хятадаар дамжиж АНУ-д гардаг байсан юм. Бүтээгдэхүүний хувьд Японоос авчирсан сэлбэг материалуудыг Хятадад угсран гаргаж байжээ. Жишээ нь АНУ-ын Хятадтай байгуулсан худалдааны салбар дахь хамтын ажиллагааны хүрээнд Хятадад үйлдвэрлэсэн дүрс бичлэгийн камер Америкийн зах зээлийг бүрэн хангаж байна. Энэ нь үнэн хэрэгтээ Хятадын бараанд ногдуулсан нэмүү өртөгийн татвар нь Япон барааны үнэ ханшнаас бага байдагт асуудлын гол нь оршино. Эцсийн бүтээгдэхүүнийг Хятадад угсрах нь мэдээжийн хэрэг хөдөлмөрийн бүтээмжийг өндөр болгож байхад Япончуудын хувьд электроникийн үйлдвэрийн бүтээгдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрахад өндөр өртгийг шаардаж байдаг юм байна.

Үүний сонгодог жишээ нь Apple-ийн амжилттай нэвтрүүлсэн iPod юм. Merrill Lynch-ийн тооцоолсноор албан ёсоор энэ нь Хятадад хийгдсэн гэдэг ч тухайн бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийн 82 хувь нь Японд үйлдвэрлэгдсэн байдаг аж. (December 02, 2008)

Санхүүгийн хямралыг хохирол багатай тойрон гарч байгаа орнуудын тоонд манай хоёр их хөрш зүй ёсоор орно. Хоёр хөршийн бодлого, үйл ажиллагаа банкуудыг дэмжихэд бус үйлдлэрлэгчдийг дэмжихэд чиглэж байгаагаараа онцлогтой. Хятадын эрх баригчид үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор 100 тэрбум юань гаргасан бол Орос томоохон экспортлогчиддоо илүү анхаарал тавьж халамж үзүүлэх шийдвэр гаргалаа. Мэдээж хэрэг хөршүүдэд хямралын улмаас ямар ч хохирол амсаагүй гэсэн үг биш. Хятадын гол экспорлогч Америкт байдал хүнд байгаагаас экспорт буурсан. Үүний улмаас ажилгүйдэл нэмэгдэж, хэрэглээний барааны үнэ өсч байна. Түүнийг саармагжуулахын тулд Хятадын засгийн газар 2009 онд зөвхөн нийгмийн хэрэгцээнд зориулж 2.64 триллион ам.доллар гаргах аж. (2008.11.29) Эдийн засгийн өсөлт буурч байгаа хэдий ч валютын асар их нөөц хуримтлуулсан, үсрэнгүй хөгжиж байгаа том гүрний хувьд хямралыг ажралгүй даван туулж байна. Оросын хувьд нефтийн үнийн бууралт эдийн засагт хүнд цохилт болох хэдий ч байгалийн баялгийн экспортоос бий болгосон эрсдлийн сангийн ачаар хямралыг ажралгүй даван туулж байна. Өнөөдөр Оросын алт, валютын нөөц 450 триллион ам.доллар болж дэлхийд гуравдугаарт орж байна. Чухамдаа энэ их нөөц л Оросын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйл болж буйг ОХУ-ын Ерөнхий сайд В.Путин 2008 оны 12-р сарын эхээр ард иргэдийнхээ асуултад телевизээр хариулт өгөхдөө мэдэгдсэн билээ. (2008.12.09)

Хоёр их хөршийн энэ байдал манай эдийн засагт яах аргагүй эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Хоёр гол импортлогчийн маань эдийн засаг ажрахгүй байна гэдэг бидний хувьд тэнгэрийн умдаг атгалаа л гэсэн үг.

Манай Засгийн газрын хувьд өнөө л хуучирсан тоглоомын дүрэм болох гал унтраах түр зуурын арга хэмжээнд л хомсхон нөөцөө тэр чигээр нь өргөн барихад л бүх үйл ажиллагаа нь одоохондоо чиглэж байгааг Дэлхийн банкы эдийн засагчид сануулсаар байгаа юм. Хоёр их хөршийн бодлого үйл ажиллагааг манайхтай харьцуулаад үзэхэд л бүх юм тодорхой харагдаж байна. Үүнийг жижиг зах зээлийн эдийн засагтай орны зовлон хэмээн зөвтгөн зөөлрүүлж болохгүй биз ээ.

Хямрал манайд нүүрлэх нь бүү хэл нөлөөлөх ямар ч үндэсгүй бид санхүүгийн хямралыг зохиомлоор импортлож байна хэмээн зарим эдийн засагчид үзэж байгаа нь ортой бололтой. Өнгөрөгч оны сүүлчээр манай улсад зохион байгуулсан олон улсын зах зээлийн эдийн засагчдын томоохон зөвлөгөөнөөс манайд хандаж “Өнөөдөр дэлхийн санхүүгийн хямрал Монголд нөлөөлөөд байгаа юм биш. Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийн бодлого л хямралыг төгөлдөршүүлж байна” гэсэн үнэлт дүгнэлт гол учир шалтгааныг нь олоод хэлчих шиг болсон.

Энэ бүхнээс үүдэн санхүүгийн өнөөгийн хямрал манай улсын хувьд маш их ашигтай, ихээхэн чухал сургамж өгч, алдаж үл болох алтан боломж олгож байна гэж хэлж болох юм. Учир нь бид хичнээн их үрлэгэн төсөвтэй, ямар их данхайсан том төртэй билээ, ямар их нийгмийн халамж амладаг бил ээ. Энэ бүхнээ нэг эргэж харах, засаглалын технологио ариутгаж тунгалаг болгох, олигархийн аалзны торон сүлжээгээ зад татаж ил гаргах алтан боломж олгож байна.

Одоо л бид энэ хөл толгойгүй замбараагүй байдлаа эргэн харж, зөв голдрилд нь оруулж, хуулиа дээдэлж, хариуцлага хяналтаа хослуулж, голбал гадаад орчин, хөгжлийн гадаад хүчин зүйлсийг оновчтой ашиглаж, глобалчлалд дасан зохицох асуудлаа дахин нягтлан тунгааж, олон улсын тавцанд хийгээд бүс нутгийн хэмжээнд баримтлах стратегийн бодлого, зорилтоо шинээр тодорхойлж авахгүй бол глобал гадаад орчны асар хурдтай өөрчлөлтөнд дасан зохицох асуудал хүнд сорилт болон тулгарах нь байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Paul Krugman. The Return of Defression Economics and the Crisis of 2008 (December 2008) ISBN0393071014
2. Stiglitz, Joseph, E. Towards a new paradigm in Monetary Economics, Cambridge University Press, September 2003.
3. Berg, Andrew and Anne Kruger “Trade Growth, and Pverty: A Selective survey”, IMF working paper, (February, 2003)
4. Hallak, Juan carlos and James Levinsohn “Fooling Ourselves: Evaluating the Globalization and Growth Debate” NBER working paper N°10244, January, 2004
5. Plumber, Thomas and Michael Graff “Export Specialization and Economic Growth”, Review of International Political Economy vol.8, N°4 2001, pp.661-88.
6. George Sachs and Hatch Uorner “Committee on ship construction” research Project-SR-99.
7. Rodrik, Dani “How to Save Globalization from its Cheerleaders “ (September, 2007)
8. Cose, Ayhan “Financial Globalization: Beyond the Blame Game” Finance and Development, vol.44,N°1, March,2007
9. “Өдрийн сонин” 2008.12 сар
10. International Monetary Fund Report, October, 2008
11. Nayyer,Deerak “Globalization: the Game, the Players and the Rules”, The political Economy of Globalization, Springer,1997
12. <http://www.economyincrisis.org/> -America’s Economic Report-Daily (December 02, 2008)